

ЗАМ, ТЭЭВРИЙН ХӨГЖЛИЙН ЯАМНЫ 2020 ОНЫ АВЛИГЫН ЭСРЭГ ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТ

/ХАГАС ЖИЛИЙН БАЙДЛААР/

№	Хийх ажлын агуулга	Хэрэгжүүлэх үйл ажиллагаа	Гүйцэтгэлийн шалгуур үзүүлэлт	Гүйцэтгэсэн ажил
1	<p>Авлигын эсрэг, авлигаас урьдчилан сэргийлэх чиглэлээр олон нийтийг соён гэгээрүүлэх арга хэмжээг хэрэгжүүлэх</p> <p>Эрх зүйн үндэслэл:</p> <ul style="list-style-type: none"> - Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх тухай хуулийн 7.5, 7.6.1, 7.6.2; - Авлигын эсрэг хуулийн 5.1.2; - Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх тухай хуулийн 7.5; - Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх тухай хуулийн 9.1.2. - Авлигатай тэмцэх үндэсний хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөний 4.1.10.1 	<p>Авлигын эсрэг хууль тогтоомжийг сурталчлах, энэ талаархи мэдээллийг албан хаагчид, иргэд чөлөөтэй авах нөхцөлийг хангах</p>	<p>Мэдээллийн самбар, цахим хуудас, сонсгол, нээлттэй өдөрлөг, хэлэлцүүлэг, хэвлэмэл материал зэрэг боломжит хэлбэрээр сурталчилсан байна.</p>	<p>Авлигын эсрэг хууль, Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хууль, УИХ-ын Хууль зүйн байнгын хорооны 2012 оны 05 дугаар тогтоолоор батлагдсан “Албан тушаалтны хувийн ашг сонирхлын мэдүүлэг болон хөрөнгө орлогын мэдүүлгийн маягт, түүнийг бүртгэх, хянах, хадгалах журам”-ыг яамны mrttd.gov.mn/erhzui/1 цахим хуудсанд, хөрөнгө орлогын цахим мэдүүлгийн холбоосыг mrttd.gov.mn/ цахим хуудсанд тус тус байрлуулав. Мөн тус яамны “Мэдээллийн цаг”-аар Авлигын эсрэг хууль, Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуулийн холбогдох зүйл заалт, нийтийн албан тушаалтны анхаарах асуудлуудын талаар сургалтыг зохион байгуулсан.</p>
		<p>Авлигын нийгмийн хор аюулыг ухуулан таниулах, авлигыг үл тэвчих үзлийг төлөвшүүлэх зорилгоор иргэдэд зориулсан сургалт, сурталчилгааны ажлыг АТГ-тай хамтран зохион байгуулах</p>	<p>Авлигатай тэмцэх газраас бэлтгэн ирүүлсэн сурталчилгааны материалыг харьяа байгууллага, албан хаагчдад түгээж, сургалтыг</p>	<p>Авлигатай тэмцэх газраас бэлтгэн ирүүлсэн тараах материал, хэвлэмэл хуудсыг яам болон харьяа байгууллагуудын хүлээлгийн өрөө болон олон нийт их үйлчлүүлдэг хэсгүүдэд байршуулсан.</p>

			хамтран зохион байгуулсан байна.	
		Албан тушаалтан, албан хаагчдын шударга байдлыг нэмэгдүүлэхэд чиглэсэн арга хэмжээг зохион байгуулах	Шударга ёс, ёс зүй, сонирхлын зөрчлийн талаарх сургалт, хэлэлцүүлэг, ярилцлага, өдөрлөг зохион байгуулж, мэдээлэл, зөвлөмж өгсөн байна.	Зам, тээврийн хөгжлийн яамны албан хаагчдад зориулсан “Мэдээллийн цаг” арга хэмжээний үеэр ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх, иргэдэд үзүүлэх үйлчилгээн хүнд суртал, чирэгдэл үзүүлэхгүй байх чиглэлээр эрх бүхий албан тушаалтан сургалтыг зохион байгуулсан.
		АТГ-ын зохион байгуулах Авлигын эсрэг үе шаттай сургалтад яам болон харьяа байгууллагын ажилтан, албан хаагчдыг хамруулах	Сургалтад хамрагдах албан хаагчдын хуваарийг гарган батлуулж, албан хаагчдыг сургалтад бүрэн хамруулсан байна.	Авлигатай тэмцэх газраас зохион байгуулах сургалтад хамруулахаар тус яамнаас 15, харьяа байгууллагуудаас 275 албан хаагчийн нэрс, холбогдох мэдээлийг хүргүүлсэн.
2	Шинээр боловсруулж байгаа бодлогын баримт бичиг ба нийтээр дагаж мөрдөх хэм хэмжээ тогтоосон шийдвэрийн төслийг олон нийтэд танилцуулах, сонирхогч бүлгүүдтэй харилцан санал солилцох Эрх зүйн үндэслэл: - Авлигын эсрэг хуулийн 6.1.2; - Мэдээллийн ил тод байдал ба мэдээлэл авах эрхийн тухай хуулийн 7.1.5.	Иргэд, олон нийт, сонирхогч бүлгийн санал, шүүмжлэлийг цахим хуудсаар хүлээн авах боломжийг бүрдүүлэх Яамнаас санаачлан боловсруулж байгаа хуулийн төсөл болон нийтээр дагаж мөрдөх хэм хэмжээ тогтоосон шийдвэрийн төслийг цахим хуудсанд байршуулсан байх Дээрх асуудлаар иргэд, олон нийт, сонирхогч бүлгүүдтэй харилцан санал солилцсон байх	Яамны цахим хуудсанд олон нийттэй харилцах онлайн харилцах болон мэдээлэл хүлээн авах буланг ажиллуулсан байна. Хуулийн төсөл болон нийтээр дагаж мөрдөх хэм хэмжээ тогтоосон шийдвэрийн төслийг цахим хуудсанд тухай бүр байршуулсан байна. Мэргэжлийн байгууллага, төрийн бус байгууллага болон иргэд, олон нийт, сонирхогч бүлгүүдтэй уулзалт ярилцлагыг хийсэн байна.	Тус яамнаас санаачлан боловсруулж байгаа хуулийн төслүүд болон дүрэм, журмын төслийг mrttd.gov.mn/all/104 цахим хуудсанд байршуулан, иргэд, олон нийт, сонирхогч бүлгийн саналыг хүлээн авах боломжийг бүрдүүлэн ажиллаж байна. Мөн www.wrtd.gov.mn цахим хуудсанд “хуулийн төсөлд санал авч байна” буланг ажиллуулж байна. Хууль тогтоомжийн тухай хуульд заасны дагуу иргэд, олон нийт, сонирхогч бүлгүүдтэй харилцан санал солилцож хэлэлцүүлгийг зохион байгуулж байна.
3	Байгууллагын удирдлагаас гаргаж буй шийдвэрийн ил тод, нээлттэй байдлыг хангах	Удирдлагаас гаргасан төрийн болон байгууллагын нууцад хамааруулснаас бусад шийдвэрийг цахим хуудсанд байршуулах	Нууцад хамааруулснаас бусад шийдвэрийг цахим хуудсанд тогтмол байршуулсан байна.	Зам, тээврийн хөгжлийн яамны цахим хуудасны https://mrttd.gov.mn/lc/5 цонхонд

	<p>Эрх зүйн үндэслэл:</p> <ul style="list-style-type: none"> - Авлигын эсрэг хуулийн 6.1.10; - Мэдээллийн ил тод байдал ба мэдээлэл авах эрхийн тухай хуулийн 7.1.4, 9.1.5; - Авлигатай тэмцэх үндэсний хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөний 4.1.7.3 	<p>Үйл ажиллагаандаа мөрдөж байгаа хууль тогтоомж дүрэм, журам, зааврыг цахим хуудсанд байршуулах</p> <p>Удирдлагын үйл ажиллагаанд хяналт тавих боломжийг бүрдүүлэх үүднээс удирдлагын зөвлөлийн бүрэлдэхүүнд төрийн бус байгууллагын төлөөллийг оруулах</p> <p>Удирдах албан тушаалтан албан үүргээ гүйцэтгэх, шийдвэр гаргахдаа хууль бусаар өөртөө болон бусдад давуу байдал олгох үйлдлийг илрүүлэх, таслан зогсоох</p>	<p>Хууль тогтоомж дүрэм, журам, зааврыг цахим хуудсанд байршуулсан байна.</p> <p>Төрийн бус байгууллагын оролцоог хангасан байна.</p> <p>Хууль бусаар өөртөө болон бусдад давуу байдал олгох үйлдлийг шалган тогтоож, холбогдох арга хэмжээг авсан байна.</p>	<p>мэдээллийг тухай бүр байршуулан ажиллаж байна.</p> <p>Зам, тээврийн хөгжлийн яамны цахим хуудасны https://mrt.d.gov.mn/lc/7 цонхонд мэдээллийг тухай бүр байршуулан ажиллаж байна.</p> <p>Зам, тээврийн хөгжлийн сайдын зөвлөлийн бүрэлдэхүүнд</p> <p>Авлигатай тэмцэх газраас ашиг, сонирхлын зөрчил үүссэн, бусдад давуу байдал олгосон үйл ажиллагаанд Авлигатай тэмцэх газраас шалгалт явуулж, холбогдох албан тушаалтнуудад эрүүгийн хэрэг үүсгээд байна. Шүүхийн шатанд зарим хэрэг шийдвэрлэгдээд байна.</p>
4	<p>Төрийн хяналтын үйл ажиллагааны ил тод, нээлттэй байдлыг хангах</p> <p>Эрх зүйн үндэслэл:</p> <ul style="list-style-type: none"> - Авлигын эсрэг хуулийн 6.1.3 - Төрийн хяналт шалгалтын тухай хуулийн 5.17; - Авлигатай тэмцэх үндэсний хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөний 4.1.2.4 	<p>Тухайн жилд явуулах хяналт шалгалтын ажлын төлөвлөгөөг цахим хуудсанд байршуулах</p> <p>Хяналт шалгалтын дүн, шалгалтын мөрөөр авсан арга хэмжээ, түүний үр дүнгийн талаарх мэдээллийг олон нийтэд цахим хуудсаар болон хэвлэл мэдээллийн хэрэгслээр мэдээлсэн байх</p> <p>Зам, тээврийн салбарын байгууллагуудад хийх хяналт шалгалтыг урьдчилан сэргийлэх чиглэлд хандуулж, шалгалтын хэлбэрийг өөрчлөх</p>	<p>Хяналт шалгалтын ажлын төлөвлөгөөг тогтоосон хугацаанд цахим хуудсанд байршуулсан байна.</p> <p>Хяналт шалгалтын мэдээллийг олон нийтэд шуурхай хүргэсэн байна.</p> <p>Хяналт шалгалтын 50-70 хүртэл хувийг урьдчилан сэргийлэх зорилгоор зохион байгуулсан байна.</p>	<p>Зам, тээврийн хөгжлийн яамны https://mrt.d.gov.mn/t/148 цахим хуудсанд байршуулсан.</p> <p>Хийсэн хяналт шалгалтынхаа дүнг олон нийтэд мэдээлсэн байх</p> <p>Хугацаа болоогүй.</p>

5	Төсвийн орлого, түүний зарцуулалт, гадаадын зээл, тусламж, түүний хуваарилалтыг олон нийтэд тухай бүр мэдээлэх /цахим хуудсаараа/	2021 оны төсөв, 2020 оны болон улирал, сарын төсвийн гүйцэтгэл, санхүүгийн тайланг яамны цахим хуудсанд байршуулж олон нийтэд мэдээлэх	Мэдээллийг тогтоосон хугацаанд бүрэн байршуулсан байна.	2019 оны төсөв, 2018 оны болон улирал, сарын төсвийн гүйцэтгэл, санхүүгийн тайланг тухай бүр shilendans.gov.mn/org/418?group=0&year=2019 байршуулан ажиллаж байна.
	Эрх зүйн үндэслэл: - Авлигын эсрэг хуулийн 6.1.4; - Мэдээллийн ил тод байдал ба мэдээлэл авах эрхийн тухай хуулийн 9 дүгээр зүйл - Авлигатай тэмцэх үндэсний хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөний 4.1.3.3, 4.1.3.4	Санхүүгийн тайланд хийсэн аудитын дүгнэлт, уг дүгнэлтэд тусгагдсан асуудлаар авч хэрэгжүүлсэн арга хэмжээний талаар мэдээлэх	Мэдээллийг тогтоосон хугацаанд бүрэн байршуулсан байна.	Хугацаа болоогүй
		Төсвийн орлого бүрдүүлэлтийг нээлттэй болгох /татварын орлого, татварын бус орлогын талаарх мэдээлэл/	Мэдээллийг тогтоосон хугацаанд бүрэн байршуулсан байна.	Хугацаа болоогүй
		Хууль тогтоомжийн дагуу төвлөрүүлэх төлбөр, хураамж, зохицуулалтын үйлчилгээний хөлсний хэмжээнд орсон өөрчлөлтийг мэдээлэх	Мэдээллийг тогтоосон хугацаанд бүрэн байршуулсан байна.	Хууль тогтоомжийн дагуу төвлөрүүлэх төлбөр, хураамж, зохицуулалтын үйлчилгээний хөлсний хэмжээнд орсон өөрчлөлтийн мэдээллийг https://mrt.d.gov.mn/lc/7 хуудсаар мэдээллэж байна.
		Гадаадын зээл, тусламжаар хэрэгжиж буй төсөл, хөтөлбөр, түүний хэрэгжилтийн талаарх мэдээлэл	Мэдээллийг тогтоосон хугацаанд бүрэн байршуулсан байна.	Гадаадын зээл, тусламжаар хэрэгжиж буй төслүүдийн талаарх мэдээллийг mrt.d.gov.mn хуудасны төсөл хөтөлбөрүүд хэсэгт байршуулан ажиллаж байна.
		Засгийн газрын тусгай сангийн санхүүжилт, зарцуулалтын мэдээллийг Шилэн дансны нэгдсэн цахим хуудсанд байршуулж олон нийтэд мэдээлэх	Мэдээллийг тогтоосон хугацаанд бүрэн байршуулсан байна.	Засгийн газрын тусгай сангийн санхүүжилт, зарцуулалтын мэдээллийг Шилэн дансны shilendans.gov.mn/org/418?group=0&year=2019 хуудсанд байршуулж байна.
		Төсвийн төслийн талаар яам болон харьяа байгууллагын хэмжээнд хэлэлцүүлэг явуулж, нэгж байгууллага, албан хаагчдын саналыг авч тусгах	Төсвийн төслийн талаарх хэлэлцүүлгийг зохион байгуулж, саналыг тусгасан байна.	Төсвийн төслийг боловсруулахдаа яамны холбогдох нэгжүүд болон орон нутгийн удирдлагууд, харьяа байгууллагуудаас саналыг нь авсны

				үндсэн дээр боловсруулж, Засгийн газарт хүргүүлсэн.
6	<p>Тусгай зөвшөөрөл, бүртгэлийн үйл ажиллагааг ил тод, нээлттэй байлгах, олон нийтэд танилцах боломжоор хангах</p> <p>Эрх зүйн үндэслэл: - Авлигын эсрэг хуулийн 6.1.5; - Мэдээллийн ил тод байдал ба мэдээлэл авах эрхийн тухай хуулийн 7.1.8</p>	Байгууллагаас олгож буй зөвшөөрөл /тусгай зөвшөөрөл, лиценз, эрх олгох г.м бусад үйл ажиллагаа эрхлэх зөвшөөрөл/-ийн жагсаалтыг цахим хуудсанд шинэчлэн байршуулах	Олон нийтэд хэрэгцээтэй мэдээллийг ойлгомжтой байдлаар байршуулсан байна.	<p>Зам, тээврийн хөгжлийн яамнаас олгодог тусгай зөвшөөрөл, гэрчилгээний жагсаалт, түүнийг олгоход шаардлагатай баримт бичгийн жагсаалтыг тухай бүр шинэчлэн https://mrt.d.gov.mn/t/119 хаягаар салбар бүрээр байршуулан ажиллаж байна.</p> <p>Тухайн зөвшөөрөл эзэмшигчийн нэр, хаяг, эрхлэх үйл ажиллагааны чиглэл, зөвшөөрөл аж ахуйн нэгжүүдийн мэдээллийг тухай бүр , зөвшөөрөл олгосон болон дуусгавар болох хугацааны мэдээллийг оруулан https://mrt.d.gov.mn/t/119 хуудсанд байршуулж байна.</p> <p>Тусгай зөвшөөрөл, гэрчилгээний тэмдэгтийн хураамжийн төлбөрийн мэдээллийг https://mrt.d.gov.mn/t/119 сайтад байршуулсан.</p> <p>Зам, тээврийн салбарын статистик, нэгдсэн бүртгэлийг улирал бүрээр гаргаж https://mrt.d.gov.mn/t/88 хуудсаар олон нийтэд мэдээллэн ажиллаж байна.</p>
		Дээрх зөвшөөрөл олгоход шаардлагатай баримт бичгийн жагсаалт, уг асуудлыг шийдвэрлэх журмыг цахим хуудсанд шинэчлэн байршуулах	Шаардлагатай мэдээллийг бүрэн байршуулсан байна.	
		Тухайн зөвшөөрөл эзэмшигчийн нэр, хаяг, эрхлэх үйл ажиллагааны чиглэл, зөвшөөрөл олгосон болон дуусгавар болох хугацааг цахим хуудсандаа байршуулах	Үнэн зөв мэдээллийг ойлгомжтой байдлаар байршуулсан байна.	
		Үйлчлүүлэгчээс авч буй төлбөр, хураамжийг цахим хуудсанд байршуулах	Олон нийтэд хэрэгцээтэй мэдээллийг бүрэн байршуулсан байна.	
		Чиг үүргийн дагуу нууцад хамаарахаас бусад бүртгэлийн талаарх мэдээллийг цахим хуудсаараа ил тод болгох	Олон нийтэд хэрэгцээтэй мэдээллийг ойлгомжтой байдлаар байршуулсан байна.	
7	<p>Хүний нөөцийн ил тод байдлыг хангах, олон нийтийг түүнтэй танилцах боломжоор хангах</p> <p>Эрх зүйн үндэслэл: - Авлигын эсрэг хуулийн 6.1.5;</p>	Сул орон тооны зарыг цахим хуудсандаа тухай бүр шинэчлэн байршуулах	Сул орон тооны зарыг тухай бүр байршуулж олон нийтэд хүргэсэн байна.	<p>Сул орон тоо, сонгон шалгаруулалтын зарыг https://mrt.d.gov.mn/t/40 хуудсанд байршуулсан.</p>
		Сонгон шалгаруулалт явуулах талаар цахим хуудас болон олон нийтийн мэдээллийн хэрэгслээр мэдээлэх	Холбогдох мэдээллийг олон нийтэд нээлттэй мэдээлсэн байна.	

	<ul style="list-style-type: none"> - Мэдээллийн ил тод байдал ба мэдээлэл авах эрхийн тухай хуулийн 8 дугаар зүйл; - Авлигатай тэмцэх үндэсний хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөний 4.1.1.1 	<p>Төрийн албаны зөвлөлийн болон салбар зөвлөлийн дүгнэлт, нийтийн албанд томилогдохоор нэр дэвшсэн этгээдийн Хувийн ашиг сонирхлын урьдчилсан мэдүүлэг (ХАСУМ)-ийг хянасан дүгнэлтийг нээлттэй болгох</p> <p>Байгууллагын албан хаагчид, хариуцсан чиг үүрэг, харилцах утасны жагсаалтыг цахим хуудсанд шинэчлэн байршуулах</p>	<p>Дүгнэлт, мэдээллийг дотоод удирдлагын системд тогтмол байршуулж албан хаагчдад мэдээллийг хүргэсэн байна.</p> <p>Шаардлагатай мэдээллийг бүрэн байршуулсан байна.</p>	<p>Нийтийн албанд томилогдохоор нэр дэвшсэн этгээдийн Хувийн ашиг сонирхлын урьдчилсан мэдүүлэг (ХАСУМ)-ийг https://mrt.d.gov.mn/t/118 цахим хуудсанд тухай бүр байршуулсан.</p> <p>Байгууллагын албан хаагчид, хариуцсан чиг үүрэг, харилцах утасны жагсаалтыг mrt.d.gov.mn цахим хуудасны хүний нөөцийн ил тод байдал хэсэгт байршуулан тухай бүр шинэчилж байна.</p>
8	<p>Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах ажиллагааны ил тод байдлыг хангах, түүнтэй танилцах боломжоор хангах</p> <p>Эрх зүйн үндэслэл:</p> <ul style="list-style-type: none"> - Авлигын эсрэг хуулийн 6.1.4; - Мэдээллийн ил тод байдал ба мэдээлэл авах эрхийн тухай хуулийн 10 дугаар зүйл - Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 21 дүгээр зүйл, 47.4, 48.5 	<p>Худалдан авах ажиллагааны төлөвлөгөөг цахим хуудсанд байршуулах</p> <p>Тендерийн баримт бичиг, тендер шалгаруулалтыг явуулах журам, тендерийн урилгыг цахим хуудсандаа байршуулах</p> <p>Тендерт шалгарсан болон шалгараагүй оролцогчийн талаарх мэдээлэл, шалгарсан болон шалгараагүй хуулийн үндэслэл, шалтгааныг холбогдох этгээдэд мэдээлэх</p> <p>Таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий худалдан авсан бараа, ажил үйлчилгээний нэр, санхүүжилтийн хэмжээ, нийлүүлэгчийн нэр, хаягийг цахим хуудсанд байршуулах</p> <p>Худалдан авах ажиллагаанд хийсэн аудитын тайлан, дүгнэлт болон</p>	<p>Төлөвлөгөөг батлуулж, цахим хуудсанд байршуулсан байна.</p> <p>Олон нийтэд хэрэгцээтэй мэдээллийг ойлгомжтой байдлаар байршуулсан байна.</p> <p>Холбогдох мэдээллийг холбогдох этгээдэд бүрэн, шуурхай мэдээлсэн байна.</p> <p>Олон нийтэд хэрэгцээтэй мэдээллийг ойлгомжтой байдлаар байршуулсан байна.</p> <p>Аудитын тайлан, дүгнэлт, шалгалтын дүнг бүрэн байргуулсан байна.</p>	<p>Худалдан авах ажиллагааны төлөвлөгөө, Тендерийн баримт бичиг, тендер шалгаруулалтыг явуулах журам, тендерийн урилгыг тухай бүр mrt.d.gov.mn цахим хуудасны “худалдан авах ажиллагааны ил тод байдал” хуудсанд байршуулан ажиллаж байна.</p> <p>Тендерт шалгарсан болон шалгараагүй оролцогчийн талаарх мэдээлэл, шалгарсан болон шалгараагүй хуулийн үндэслэл, шалтгааныг тухай бүр мэдээллэн ажиллаж байна.</p> <p>Таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий худалдан авсан бараа, ажил үйлчилгээний нэр, санхүүжилтийн хэмжээ, нийлүүлэгчийн нэр, хаягийг https://shilendans.gov.mn/org/418?group=1&year=2019 хуудсанд байршуулсан.</p> <p>Худалдан авах ажиллагаанд хийсэн аудитын тайлан, дүгнэлт болон бусад хяналт, шалгалтын дүн</p>

		бусад хяналт, шалгалтын дүнг цахим хуудсанд байршуулах		shilendans.gov.mn/org/418?group=0&year=2019 байршуулсан.
		Тендерийн үнэлгээний хорооны бүрэлдэхүүнд мэргэжлийн холбоод, хувийн хэвшил, төрийн бус байгууллагын төлөөллийг оролцуулсан байх	Мэргэжлийн холбоод, хувийн хэвшил, төрийн бус байгууллагын оролцоог хангасан байна.	Тендерийн үнэлгээний хорооны бүрэлдэхүүнд мэргэжлийн холбоод, хувийн хэвшил, төрийн бус байгууллагын төлөөллийг оролцуулж байна.
9	Шударга, хариуцлагатай, ил тод нийтийн албыг бэхжүүлэх, төрийн жинхэнэ албан хаагчийн сонгон шалгаруулалт болон томилгоонд улс төрийн нөлөөллөөс ангид, мэдлэг, боловсролд суурилсан мерит зарчмыг хэрэгжүүлэх	Зам, тээврийн хөгжлийн яамны гүйцэтгэх албан тушаалын албан тушаалын тодорхойлолтыг шинэчлэн баталж, мөрдүүлэх	Байгууллагын болон нэгжийн үйл ажиллагааны стратегид нийцүүлж шинэчилсэн байна.	Зам, тээврийн хөгжлийн яамны удирдах, гүйцэтгэх албан тушаалтнуудын албан тушаалын тодорхойлолтыг боловсруулж, Төрийн албаны зөвлөлийн хурлаар хэлэлцүүлж, зөвшөөрөл авсны үндсэн дээр Төрийн нарийн бичгийн даргын 2019 оны 393, А/36 дугаар тушаалаар тус тус баталсан.
	Эрх зүйн үндэслэл: - Авлигын эсрэг хуулийн 6.1.9, 6.8, 6.1.6; - Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуулийн 7.2.1, 7.1.2, 7.2.4, 7.2.5, 7.2.6, 10-22 дугаар зүйл, 29 дүгээр зүйл; - Авлигатай тэмцэх үндэсний хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөний 4.1.1.2	Төрийн албаны зөвлөлийн дүгнэлт, хувийн ашиг сонирхлын урьдчилсан мэдүүлгийг хянасан байдлыг үндэслэн ажлын байранд тавигдах шаардлагыг хангасан иргэнийг албан тушаалд томилох асуудлыг шийдвэрлэж байх	Хууль тогтоомж, дүрэм журамд нийцүүлэн шийдвэрлэсэн байна.	Нийтийн албанд томилогдохоор нэр дэвшсэн этгээдийн Монгол Улсын Их хурлын Хууль зүйн байнгын хорооны 2014 оны 20 дугаар тогтоолын дагуу хувийн ашиг сонирхлын урьдчилсан мэдүүлгийг хянасан байдлыг үндэслэн ажлын байранд тавигдах шаардлагыг хангасан иргэнийг албан тушаалд томилох асуудлыг шийдвэрлэж байна.
		Ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх ёс зүйн дүрмийг тогтоон мөрдүүлэх	Ёс зүйн дүрмийг батлах, мөрдүүлэх /албан хаагчдад танилцуулсан байдал/	Монгол Улсын Засгийн газрын 2019 оны 33 дугаар тогтоолоор баталсан “Төрийн захиргааны болон үйлчилгээний албан хаагчийн ёс зүйн дүрэм”-ийг баримтлан ажиллаж байна. Ёс зүйн дүрмийн талаар Зам, тээврийн хөгжлийн яамны албан хаагчдад “Мэдээллийн цаг”-аар мэдээлэл өгсөн болно.

		Зөрчлийн талаарх мэдээлэл хүлээн авах нөхцөлийг бүрдүүлэх	Тогтмол утас ажиллуулах, цахим хуудсаар, шуудангаар, биечлэн, хайрцаг байршуулах зэрэг мэдээлэл хүлээн авах нөхцөлийг бүрдүүлсэн байна.	Зам, тээврийн хөгжлийн яамны 51263175 дугаар утсаар зөрчилтэй холбоотой мэдээллийг хүлээн авч байна. Мөн яамны хүлээн авах хэсэгт иргэдийн санал гомдлын хүлээн авах хайрцагийг байршуулан ажиллаж байна.
		Зөрчил үүссэн буюу үүсч болзошгүй тохиолдолд урьдчилан сэргийлэх арга хэмжээ авч, зөрчил илэрсэн тохиолдолд хуульд заасан хариуцлагыг хүлээлгэх	Хуулийн дагуу холбогдох арга хэмжээг авч ажилласан байна.	Тайлант хугацаанд ёс зүйн зөрчил гараагүй болно.
		Ёс зүйн дүрмийн хэрэгжилтийн байдалд хяналт-шинжилгээ хийж, дүнг хамт олонд мэдээлэх	Ёс зүйн дүрмийн хэрэгжилтийн байдлыг нээлттэй мэдээлсэн байна.	Хяналт-шинжилгээ, үнэлгээний тайланг тухай бүр https://mrt.d.gov.mn/t/98 байршуулж байна.
		Албан хаагчдын ажлын гүйцэтгэлийг үнэлэх үйл ажиллагааг үнэн зөв, шударга болгох чиглэлээр арга хэмжээ авах	Албан хаагчдын ажлын гүйцэтгэлийн үнэлгээ бодитой болсон байна.	Албан хаагчдын ажлын гүйцэтгэлийг үнэлэхдээ нэгжийн даргын ажлын гүйцэтгэлийг харгалзах чиглэлийг баримталж, үйл ажиллагаанд хангалтгүй дүгнэгдсэн ажлуудтай уялдуулан албан хаагчдын ажлын гүйцэтгэлийг үнэлж байна.
		Албан хаагчдын давхар ажил эрхлэх боломжтой эсэхийг судлан шийдвэрлэх, давхар ажил эрхлэлтийн талаарх судалгаа гаргах	Давхар эрхэлж болох ажлын жагсаалтыг албан хаагчдад танилцуулж, давхар ажил эрхлэлтийн талаарх судалгаатай болсон байна.	Одоогоор давхар ажил эрхэлж байгаа албан хаагч байхгүй болно.
10	Авлигатай тэмцэх зорилго бүхий төрийн бус байгууллага, иргэдийн сайн дурын хөдөлгөөнийг дэмжих, үйл ажиллагаандаа татан оролцуулах	Авлигатай тэмцэх чиглэлээр төрийн бус байгууллага, иргэдтэй хамтран хэрэгжүүлэх үйл ажиллагааны чиглэлийг тогтоох	Хамтран хэлэлцэж, хэрэгжүүлэх үйл ажиллагааны чиглэлийг тогтоосон байна.	Хугацаа болоогүй
	Эрх зүйн үндэслэл:	Тодорхой төрлийн үйл ажиллагааны хэрэгжилт, явц байдалд хяналт тавих, судалгаа, дүн шинжилгээ, үнэлгээ хийх 2-оос доошгүй ажлыг	Иргэний нийгмийн байгууллагаар 2-оос доошгүй ажлыг үр дүнтэй гүйцэтгүүлсэн байна.	Хугацаа болоогүй

	<p>- Авлигын эсрэг хуулийн 6 дугаар зүйлийн 6.1.7, 6.1.13; - Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.6.3; - Авлигатай тэмцэх үндэсний хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөний 4.1.2.3, 4.1.2.7, 4.1.7.1, 4.1.7.4</p>	<p>иргэний нийгмийн байгууллагаар гүйцэтгүүлсэн байх</p> <p>Зарим төрлийн зөвшөөрөл олгох, хяналт тавих чиг үүргийг төрийн бус байгууллагад шилжүүлэх асуудлыг судалж, санал дэвшүүлэх</p> <p>Яамны дэргэдэх авлигаас урьдчилан сэргийлэх олон нийтийн хяналтын дэд зөвлөлтэй хамтран ажиллах</p>	<p>Судалгаанд үндэслэн шийдвэрлэх боломжтой саналыг дэвшүүлсэн байна.</p> <p>олон нийтийн хяналтын дэд зөвлөлийг ажиллах боломжоор хангаж, үр дүнтэй хамтран ажилласан байна.</p>	<p>Авто зам барих, засварлах тусгай зөвшөөрөл олгох журам"-ын дагуу иргэн, аж ахуйн нэгжийн тусгай зөвшөөрөл хүссэн өргөдлийг хүлээн авч мэргэжлийн дүгнэлт гаргах чиг үүргийг “Автозамчдын нэгдсэн холбоо” ТББ-аар гүйцэтгүүлж байна. Түүнчлэн яамнаас байгуулсан ажлын хэсэг, комисс, зөвлөлд холбогдох төрийн бус байгууллагын төлөөллийг оролцуулах нөхцлийг хангаж ажиллаж байна. Тухайлбал, худалдан авах ажиллагааг зохион байгуулах үнэлгээний хороонд төрийн бус байгууллагын төлөөллийг оролцуулан ажиллуулж байна. Мөн төрийн үйлчилгээний зарим чиг үүргийг гүйцэтгүүлэхээр тус яамнаас “Автозамчдын нэгдсэн холбоо”, “Төмөр замчдын нэгдсэн холбоо”, “Автотээвэрчдийн нэгдсэн холбоо”, “Агаарын тээвэрлэгчдийн нэгдсэн холбоо” төрийн бус байгууллагуудтай хамтын ажиллагааны гэрээ байгуулан ажиллаж байна.</p> <p>Хугацаа болоогүй</p>
11	Иргэдийн өргөдөл гомдол, санал, хүсэлтийг хүлээн авах, шийдвэрлэх шат дамжлагыг цөөрүүлэх, зөрчлийн талаарх	Өргөдөл /санал, мэдэгдэл/, гомдол, хүсэлт, мэдээлэл хүлээн авах нөхцлийг бүрдүүлсэн байх	Иргэдийн өргөдөл гомдол, санал, хүсэлтийг утас, хайрцаг, санал хүсэлтийн дэвтэр, факс, цахим, бичгээр, амаар зэрэг	Өргөдөл, гомдлын мэдээллийг хүлээн авах нөхцөлийг бүрдүүлэн ажиллаж байгаа ба 6226-3175 дугаарын утсаар, 312315 факсаар, mrt.d.gov.mn цахим хуудасны

	<p>мэдээллийг хүлээн авч шалгах</p> <p>Эрх зүйн үндэслэл:</p> <ul style="list-style-type: none"> - Авлигын эсрэг хуулийн 6.1.11; - Мэдээллийн ил тод байдал ба мэдээлэл авах эрхийн тухай хуулийн 7.1.2; - Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуулийн 7.2.3; - Иргэдээс төрийн байгууллага албан тушаалтанд гаргасан өргөдөл, гомдлын шийдвэрлэх тухай хуулийн 7.8, 7.9, 19.3; - Авлигатай тэмцэх үндэсний хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөний 4.1.1.7 		<p>хэлбэрээр хүлээн авах боломжтой болсон байна.</p>	<p>“өргөдөл гомдол”, “санал хүсэлт” булангаар, 11-11 төвөөр болон бичгээр, амаар иргэдээс өргөдөл, гомдлыг хүлээн авч байна.</p>
		<p>Үйлчилгээ, захидал харилцааны асуудал хариуцсан албан хаагчийн нэр, албан тушаал, ажиллах журам, харилцах утас, иргэдийг хүлээн авч уулзах цагийн хуваарийг цахим хуудас болон мэдээллийн самбарт байршуулах</p>	<p>Олон нийтэд шаардлагатай мэдээллийг бүрэн, ойлгомжтой байдлаар цахим хуудсанд байршуулсан байна.</p>	<p>Холбогдох мэдээллийг зам, тээврийн хөгжлийн яамны цахим хуудасны хүний нөөцийн ил тод байдал хэсэгт тухай бүр байршуулан ажиллаж байна.</p>
		<p>Албан тушаалтанд холбогдох авлига, ашиг сонирхол, ёс зүйтэй холбоотой өргөдөл, гомдол, мэдээллийг хүлээн авах, хянан шалгах, шийдвэрлэх үйл ажиллагааг хуулийн хүрээнд хэрэгжүүлэх</p>	<p>Хууль тогтоомжийн дагуу холбогдох арга хэмжээг авч ажилласан байна.</p>	<p>Тайлант хугацаанд зөрчил гараагүй болно.</p>
		<p>Иргэдийн өргөдөл гомдол, санал, хүсэлт, мэдээллийг шийдвэрлэсэн талаар цахим хуудсаар тогтмол хугацаанд мэдээлсэн байх</p>	<p>Мэдээллийг олон нийтэд тогтмол хүргэсэн байна.</p>	<p>Зам, тээврийн хөгжлийн яамны https://mrt.d.gov.mn/t/107 хуудсаар мэдээллийг тухай бүр байршуулан ажиллаж байна.</p>
15	<p>Авлигын эрсдэл ба авлига гарах боломжийг бууруулах</p> <p>Эрх зүйн үндэслэл:</p> <ul style="list-style-type: none"> - Авлигын эсрэг хуулийн 6.1.12; - Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх тухай хуулийн 9.1.1 	<p>Авлигад өртөх эрсдэлтэй ажил, албан тушаал, үйлчилгээний жагсаалтыг гаргах</p>	<p>Судалгаа, шинжилгээнд үндэслэн бодитой, оновчтой гаргасан байна.</p>	<p>Хугацаа болоогүй.</p>
		<p>Авлигын эрсдэл ба авлига гарах боломжийг бууруулах чиглэлээр холбогдох арга хэмжээг авч хэрэгжүүлэх</p>	<p>Хүнд суртал, чирэгдлийг багасгах, сөрөг үзэгдлийг хаах, мэдэгдэл гаргах, албан хаагчийн ажлын байрыг сэлгүүлэх зэрэг үр дүнтэй арга хэмжээг зохион байгуулсан байна.</p>	<p>Хугацаа болоогүй.</p>

		Албан тушаалтан томилогдсоноос хойш хуульд заасан хугацаанд хувийн ашиг сонирхлын болон хөрөнгө, орлогын мэдүүлэг гаргах чиглэлээр зохион байгуулалтын арга хэмжээ авах, мэдүүлгээ хугацаанд нь гаргаагүй албан тушаалтанд хариуцлага тооцох	Албан тушаалд томилогдсон албан хаагчийн хувийн ашиг сонирхлын болон хөрөнгө, орлогын мэдүүлгийг хуулийн хугацаанд гаргуулж хэвшүүлсэн байна.	Нийтийн албан тушаалд томилогдсоноос хойш хуульд заасан хугацаанд хувийн ашиг сонирхлын болон хөрөнгө, орлогын мэдүүлгийг гаргуулж, бүртгэлийг хөтөлж байна. Тайлант хугацаанд хугацаа хоцроосноос шалтгаалж хариуцлага тооцсон албан хаагч байхгүй байна.
		Захиргааны шийдвэр гаргах, удирдах, хяналт, шалгалт хийх, хариуцлага хүлээлгэх, гэрээ байгуулах, эдгээрийг хэлэлцэх, бэлтгэх, оролцохын өмнө албан тушаалтнаар тухай бүр ашиг сонирхлын зөрчилгүй гэдгээ илэрхийлсэн мэдэгдэл гаргаж хэвшүүлэх	Албан тушаалтнаар тухай бүр ашиг сонирхлын зөрчилгүй гэдгээ илэрхийлсэн мэдэгдэл гаргаж хэвшүүлсэн байна.	Мэдэгдэл тайлбарыг тухай бүр гаргуулан авч, бүртгэлийг хөтөлж байна.
16	<p>Авлигатай тэмцэх газраас бүрэн эрхийнхээ дагуу гаргасан шийдвэрийг биелүүлэх</p> <p>Эрх зүйн үндэслэл:</p> <ul style="list-style-type: none"> - Авлигын эсрэг хуулийн 6.6, 6.7, 18.4.2, 29.4; - Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх тухай хуулийн 9.2 	Авлигатай тэмцэх газрын зөвлөмжийг хэрэгжүүлэх үйл ажиллагааг зохион байгуулах	Төлөвлөгөөний хэрэгжилтийг бүрэн хангаж ажилласан байна.	Авлигатай тэмцэх газраас 2020.03.25-ны өдрийн 01/3542 албан тоот бичгээр ирүүлсэн зөвлөмжийг Сайдын зөвлөлийн хуралдаанаар хэлэлцүүлэн хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөг батлуулсан. Төлөвлөгөөний хэрэгжилтийг ханган ажиллаж байна.
		АТГ-ын мөрдөн байцаагчаас гэмт хэргийн шалтгаан нөхцөлийг арилгуулахаар ирүүлсэн мэдэгдлийн дагуу холбогдох арга хэмжээ авах	Мэдэгдлийн дагуу холбогдох арга хэмжээг бүрэн авч ажилласан байна.	Тайлант хугацаанд Авлигатай тэмцэх газраас гэмт хэргийн шалтгаан нөхцөлийг арилгах чиглэлээр мэдэгдэл ирүүлээгүй байна.
		АТГ-аас зөрчил арилгуулах, хариуцлага тооцож, арга хэмжээ авахуулахаар ирүүлсэн албан бичгийн дагуу холбогдох арга хэмжээ авах	АТГ-ын албан бичгийн дагуу холбогдох арга хэмжээг бүрэн авч ажилласан байна.	Тайлант хугацаанд давхар ажил эрхлэлтийн талаар мэдэгдээгүй, нийгмийн даатгал давхар төлүүлж холбогдох хууль тогтоомжийг зөрчсөн тус яамны ТЗДТБХЗГ-ын мэргэжилтэн Г.Баттуяа, АЗБХЗГ-ын шинжээч Б.Минжбадам нарт

				сахилгын шийтгэл ногдуулж, холбогдох шийдвэрийг Авлигатай тэмцэх газар, Төрийн албаны зөвлөлд тус тус хүргүүлсэн.
		Авлига гарах нөхцөл боломжийг бүрдүүлсэн гэж үзсэн дүрэм, журам, заавар, шийдвэрийг өөрчлөх буюу хүчингүй болгох	Холбогдох дүрэм, журам, заавар, шийдвэрийг өөрчлөх, хүчингүй болгох асуудлыг судлан шийдвэрлэсэн байна.	Хугацаа болоогүй.
	Төрийн үйлчилгээний нээлттэй байдлыг хангаж, цахим үйлчилгээг хөгжүүлж, чанар хүртээмжийг сайжруулах	Албан хэрэг хөтлөлтийн системийг салбарын болон төрийн байгууллагын хэмжээнд бүрэн ашиглаж хэвших	Албан хэрэг хөтлөлтийн системийн ашиглалтыг сайжруулсан байна.	Цахим албан хэрэг хөтлөлтийг яамны хэмжээнд бүрэн нэвтрүүлсэн ба нийт харьяа байгууллагуудын хэмжээнд 2020 оны 4 дүгээр улиралд багтаан цахим хэлбэрт шилжүүлэхээр ажиллаж байна.
	Эрх зүйн үндэслэл: Авлигатай тэмцэх үндэсний хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөний 4.1.1.9, 4.1.2.1	Тусгай зөвшөөрөл олгох үйл ажиллагааг цахим хэлбэрт шилжүүлэх арга замыг судалж, төсөл боловсруулж хэрэгжүүлэх	Үйл ажиллагааны өнөөгийн байдлын судалгааг хийж, төслийн үндэслэл, эдийн тооцооллыг нарийн бодитой хийсэн байна.	Тусгай зөвшөөрөл олгох үйл ажиллагаа, зам, тээврийн хөгжлийн яамнаас үзүүлж буй бусад үйлчилгээг цахим хэлбэрт шилжүүлэх үйл ажиллагааг 2020 оны 11 дүгээр сард багтаан дуусгахаар ажиллаж байна.